



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/88

Зуунмод сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1, 60.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн эх үүсвэрээр хэрэгжиж буй Сургуулийн барилга 920 суудал (Төв.Батсүмбэр сум) барилгын нэмэлт ажил худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Ц.Буманбуян (Төв аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

С.Аюурзана (Төв аймгийн “Барилга захиалагч, орон сууцны корпораци” ОНӨААТҮГ-ын инженер)

Ж.Чинзориг (Төв аймгийн “Барилга захиалагч, орон сууцны корпораци” ОНӨААТҮГ-ын нягтлан)

Д.Дашдаваа (Иргэний төлөөлөл), (Аймгийн иргэдийн төлөөлөгчийн хурлын Тэргүүлэгчдий 2019 оны 119 дүгээр тогтоол)

Нарийн бичгийн дарга:

Г.Тамирмаа (Төв аймгийн Орон нутгийн газрын худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ц.Буманбуян)-д, ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг чанд баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулахыг Төв аймгийн “Барилга захиалагч, орон сууцны корпораци” ОНӨААТҮГ-ын (Ж.Баттөгс)-т, шилэн дансанд мэдээлэхийг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга (А.Зоригоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4122013266